

ММСГНийгэмлэгийн 2022 оны үйл ажиллагааны тайлан

ММСГНийгэмлэгээс тайлангийн хугацаанд хэрэгжүүлсэн ажлын талаар:

А. Зохион байгуулалт, сурталчилгааны чиглэлээр

1. Нийгэмлэгийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл дээр Удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг авч тусган боловсруулж, УЗ-ийн даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Нийт 24 заалт бүхий төлөвлөгөөний хэрэгжилт 2 ажил огт хэрэгжээгүй, 1 ажил 60% ерөнхий гүйцэтгэл 90 % байна.
2. Нийгэмлэгийн үйл ажиллагааны тайланг „Төрийн бус байгууллагын тухай хууль”-ийн дагуу Улсын Бүртгэлийн Газарт дараа оны 2-р сарын 15-ны дотор албан ёсоор гарган өгч ажилласан ба татвар, нийгмийн даатгалын төлбөр, тооцоо, тайланг хуулийн хугацаанд хийж, тайлагнаж ирлээ.
3. Нийгэмлэгийн үндсэн зорилт, үйл ажиллагаа, тайлан болон цаашид хэрэгжүүлэх ажлын талаар гишүүн байгуулагууд, ААНБ, хувь хүмүүст танилцуулах, сурталчлах, гагнуурын мэргэжлийг олон нийтэд түгээх зэрэг ажлууд байнга явууллаа.
4. Мэргэжлийн туслалцаа авах, хамтран ажиллах, ажил төрлийн холбоо тогтоох, сургалтанд хамрагдах, зөвөлгөө авах чиглэлээр нийгэмлэгт хандсан ААНБ, хувь хүмүүст туслалцаа үзүүлж ажиллалаа.
5. Монголын анхны гагнуурын мэргэжлийн „Гагнуур” сэтгүүлийн 3 дахь дугаарыг дангаар гаргаж гишүүн байгуулагууд, ААНБ, хувь хүмүүст 300 ш тараасан байна. Сэтгүүлийн энэ дугаарт мэргэжлийн гагнуурчдын үр чадварын тэмцээний хагас автомат төрөлд 3 удаа түрүүлж байсан гагнуурчин М.Ганхуягийн ярилцлага, олон улсад гагнуураар багшлах эрх бүхий багш Н.Ганхуягийн талаарх нийтлэл, MNS ISO 9606-1:2021 стандартын танилцуулга, нийгэмлэгийн 2021 оны үйл ажиллагааны товч мэдээлэл, Ханноверийн гагнуурын техникийн сургалт судалгааны төвийн талаар зэрэг материалуудыг гаргасан.
6. Нийгэмлэгийн www.mmsws.mn веб сайтыг Suprassist ХХК-тай 1.1 сая төгрөгөөр гэрээ байгуулан шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэн, мэдээлэл, материалуудыг шинэчилж сайжрууллаа. Веб сайтад нийгэмлэгийн мэдээллийг тогтмол тавьж ажиллаж байна.
7. Гүйцэтгэх захирлын зүгээс Эрдэнэтийн УБУ-ийн РМЗ-ын гагнуурчид, ИТА нарт „Нийгэмлэгийн танилцуулга, үйл ажиллагааны тухай” хичээл/4-р сарын 11,12/, ГОУХАН-ийн стратегийн түншлэлийн хүрээнд „Монгол улсын мэргэжлийн боловсролын салбарт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх” сэдвээр Эрдэнэт хотод болсон семинарт „Шалгалт авах эрх бүхий байгууллагын концепцын тухай” танилцуулга / 5-р сарын 11,12/, ХНХЯам, ГОУХАН хамтран хэрэгжүүлдэг, „Ур чадварыг хөгжүүлэх” төслөөс зохион байгуулсан „Дэлхийн стандартыг нутагшуулах нь” сэдэвт „Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн гэрээлэгч ААНБ болон мэргэжлийн сургалтын байгууллагуудын дэргэдэх мэргэжлийн зөвлөлүүдийн Улаанбаатар хотод болсон түршлага солилцох уулзалт дээр „ММСГН болон гагнуурын мэргэжлийн 6 стандартын талаар” танилцуулга /4-р сарын 15/ тус тус хийж нийгэмлэгээ сурталчлав. Мөн „Мэргэжлийн боловсролын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын ХНХЯ-ы ажлын хэсэгт орж ажиллалаа.
8. Эрчим хүчний салбарын 100 жилийн ойд зориулсан 1-р ном болох „Монголын эрчим хүч 100 үйл явдал” номны 58-р үйл явдал „Салбартаа дэмтэй мэргэжлийн холбоод хэсэгт” нийгэмлэгийн талаар оруулж мөн

2-р ном болох „Эрин зууны түүхтэй илч гэрлийн эзэд” номны „Төрийн бус байгууллагууд” хэсэгт Монголын материал судлал гагнуурын нийгэмлэг-ийн танилцуулга, зургуудын хамт 3-нүүр материал бэлдэж өгч оруулан нийгэмлэгээ сурталчлав.

9. ГОУХАНИйгэмлэгийн „Гагнуурын салбар дахь стратегийн түншлэл”-ийн хүрээнд 2 талын ажлын хэсгийн хурал зөвлөгөөнд оролцож ирлээ.



10. ГОУХАНИйгэмлэгтэй хамтран гагнуурын мэргэжлийн чиглэлийн 56 ш номны нэрсийг нүүр хуудасны зургийн хамт гаргаж нийгэмлэгийн веб сайтад байрлуулсан.




Б. Атестатчлал, сургалт, стандартын чиглэлээр

1.Эрдэс баялаг эрчим хүчний сайдын 2010 оны 01-р сарын 25-ны өдрийн 21 тоот тушаалаар батлагдсан „Гагнуурчид гагнуурын инженер техникийн ажилтныг мэргэшүүлэх зэрэг олгох дүрэм”-ийн дагуу Оюутолгой ХХК, Хасу Мегаватт ХХК, ИШТХҮ ЗЭТ ЭМ И ХХК зэрэг компани, ААНБ болон хувь хүн зэрэг нийт 343 мэргэжлийн гагнуурчдаас гагнуурын атестатчлалын шалгалт авч атесстат олгосон байна. Үүнээс 260 ГММСҮТ

2.ЗЭТ ЭМ И ХХК, ИШТХҮ байгууллагуудын 12 ИТА, Эрдэнэт үйлдвэрийн 10 ИТА, 22 гагнуурчинд „Гагнуурын гадаад оёдлын гадна дотоод гэмтэл согогийг судлах” сургалт,Хасу Мегаватт ХХК Лайньюкс ХХК MCS International ХХК зэрэг байгууллагуудын 22 ИТА нарт „Гагнуурын мастер сургалт” зохион байгуулж эдгээр сургалтуудад нийт 66 хүн хамрагджээ.



3. ISO/IES 17024 стандартын дагуу Үндэсний итгэмжлэлийн Газраас /ҮИГ/ гагнуурын аттестатчлал явуулах эрх бүхий итгэмжлэл авах ажлыг зохион байгуулж 50 хуудас бүхий „Чанарын гарын” боловсруулан албан ёсоор ҮИГазарт хүргүүллээ. Үүний дагуу ҮИГ-аас 3 хүний бүрэлдэхүүнтэй баг ирж танилцан үл тохирлуудын талаар зөвлөмж өгсөн. Зөвлөмжийн дагуу үл тохирлуудыг арилган албан тоотоор хариу хүргүүлснээр ҮИГ-аас дахин 3 хүний бүрэлдэхүүнтэй албан ёсны баг томилогдон хамтран ажиллаж байгаа болно.



В. Мэргэжлийн уралдаан тэмцээний чиглэлээр


1. Мэргэжлийн гагнүүрчдын үр чадварын улсын аварга шалгаруулах 6 дахь удаагийн тэмцээнийг 2021 оны 12-р сарын 1-4-ний өдрүүдэд ГММСҮТөв дээр зохион байгуулав.

Тэмцээнийг цахилгаан (111/SMAW), хагас автомат (135/GMAW), аргон (141/GTAW) гагнүүрын 3 төрлөөр явуулсан.

Мэргэжлийн тэмцээнд эрчим хүч, уул уурхай, иргэний нисэх, төмөр зам, мэргэжил сургалтын төвүүд зэрэг салбарын 26 байгууллага, аж ахуйн нэгж болон хувиараа оролцогсод 17-44 насны нийт 80 шилдэг гагнүүрчид үр чадвараа сорьсон.

Цар тахлын дараах анхны энэ тэмцээнд өмнөх улсын аваргын тэмцээний шилдгүүд, ARC CUP тэмцээний медальтнууд, Бразил, АНЭУ, ОХУ, АНУ-д болсон Дэлхийн үр чадварын WORLDSKILLS ISO тэмцээний үндэсний оролцогч нар өрсөлдсөнөөрөө онцлог байв.

Тэмцээнийг О.Мөнхтөгсөөр ахлуулсан 7 шүүгч сорьцуудад стандартын дагуу гадна, дотоод үзлэг хийн дүгнэсэн. Үнэлгээнд ХБНГУ, Монголын хамтарсан „Гагнүүрын салбар дахь стратегийн түншлэл” төслийн хүрээнд нийлүүлэгдсэн HD-CR-35-NDT маркийн орчин үеийн дижитал аппарат хэрэгслийг амжилттай ашиглав. Дижитал аппаратны ашиглах зааврыг монгол хэл дээр орчуулах ажлыг Луних ХХК хийж гүйцэтгэсэн.



Тэмцээний дүнгээр:

Цахилгаан гагнуурын төрөлд 1-р байр Х.Бямбажав/MCS Properties ХХК/, 2-р байр Э.Батсүх /ДЦС-4 ТӨХК/.

3-р байр Б.Оргил /ДЦС-4 ТӨХК/

Хагас автомат төрөлд 1-р байр Д.Нямрагчаа /Хасу-Мегаватт ХХК/, 2-р байр Б.Өлзийбуян /Хасу- Мегаватт ХХК/, 3-р байр Ж.Жанлав-Ойдов /Оюутолгой ХХК/

Аргон гагнуурын төрөлд 1-р байр Ч.Агваандэмбэрэл /ДЦС-4 ТӨХК/, 2-р байр Э.Төмөрсүх /GCR ХХК/ 3-р байр М.Энх-Амгалан /GCR ХХК/ нар эзэллээ.

2.Дэлхийн үр чадвар/WORLDSKILLS/-ын 46 дахь удаагийн тэмцээн 2022 оны 10-р сарын 17-20-ны өдрүүдэд АНУ-ын Клевленд хотод болж гагнуурын төрөлд Монгол улсаа төлөөлөн ГММСҮТ-ийн суралцагч 17 настай Д.Амаржаргал оролцлоо. Нийгэмлэгийн УЗ-ийн гишүүн С.Батсайхан гагнуурын экспертээр 4 дэх удаа ажиллав.

Уг тэмцээнд Д.Амаржаргал 694 оноо авсан.





Г. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр

1. Японы Токио хотод 7-р сарын 14-16-нд болсон Азийн Гагнуурын Холбооны 36-р хуралд гүйцэтгэх захирал Н.Мягмарсүрэн, ажилтан Намуундарь биечлэн оролцов.

Хурлын үеэр санал хураалтанд оролцож, АГХ-ы ерөнхийлөгч Thian Slong Sze-тэй уулзаж нийгэмлэгийн ажлаас товч танилцуулсан

Индонезид 12-р сарын 16-нд болсон АГХ-ы 37-р хуралд УЗ-ийн гишүүн Ч.Анхаа цахимаар / Индонезийн талаас визний баталгаа гаргаагүй тул/оролцлоо.

2.ХБНГУ, Монгол улсын „Гагнуурын салбар дахь стратегийн түншлэл” төслийн хүрээнд гагнуурын мэргэжлээр олон улсад багшлах эрх олгох 45 хоногийн сургалт 6-р сард ГММСҮТ-д амжилттай болсон.

Сургалтыг ХБНГУ-ын мэргэжлийн багш нар явуулж, Халле хотын Гагнуурын сургалт судалгааны төвөөс 14 хүнд сертификат олгосон. Мөн суралцагсдаас 10 хүнийг Германы тал өөрийн хөрөнгөөр ХБНГУ д 14 хоног танилцах аялал зохион байгуулсан байна.

3.„Гагнуурын салбар дахь стратегийн түншлэл” төслийн хүрээнд ХБНГУ-ын Халлегийн Гагнуурын сургалт судалгааны төв дээр 5-р сарын 16-20- хооронд болсон гагнуурын гадна үзлэгийн 2 р түвшний сургалтанд УЗ-ийн гишүүн, инженер С.Батсайхан, О.Мөнхтөгс болон инженер Буян-Учрал, Энхбаатар багш Чимэддорж нар оролцож, үл эвдэх сорилын гадна үзлэг хийх шалгагчийн шалгалтыг амжилттай өглөө.

4.Мөн төслийн хүрээнд инженер С.Батсайхан, О.Мөнхтөгс нар олон улсын гагнуурын инженерийн цахим сургалтанд хамрагдаж улмаар ХБНГУ-д гагнуурын сургалт, шалгалтанд хамрагдсан.

Одоогийн байдлаар С.Батсайхан олон улсын гагнуурын инженерийн шалгалтаа амжилттай өгч дууссан дүнтэй байна.



Тайлан бичсэн/Н.Мягмарсүрэн/

2023 оны хоёрдугаар сарын 9

